



СЭЛЭНГЭ АЙМАГ  
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/В1

Баруун хараа

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх  
нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "А" дахь заалт, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.2, 4.5.3, 4.5.4, 4.5.5, 4.5.6, 4.5.7, 4.5.8, 4.5.9, 4.5.10, 4.5.11 дэх заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/132 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн эрүүл мэнд, мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, гоц халдварт, халдварт, паразиттах өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал амьтны өвчлөлийн байдлыг бүртгэх, мэдээлэх, ажил үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах, хяналт тавих зорилгоор сумын хэмжээнд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч

Б.Эрдэнэбаатар Засаг даргын тамгын газрын  
даргын үүрэг гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга

Х.Уянга	Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн	
Гишүүд	Н.Давааням	Хөдөө аж ахуйн тасгийн дарга
	Ч.Даваадорж	Батгарьд ХХК-ийн захирал
	Н.Эрдэнэбаатар	Баян таван эрдэнэ ХХК-ийн захирал
	Б.Жаргалсайхан	Дөлгөөн энэрэл ХХК-ийн захирал
	Л.Занданбат	Хараа багийн Засаг дарга
	Б.Түшигжаргал	Баян багийн Засаг дарга
	Б.Болортуяа	Гонир багийн Засаг дарга

3. Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

а/ Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд халдварт, гоц халдварт, паразиттах өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аян" арга хэмжээг 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 25-ныг хүртэл хугацаанд олон нийтийг хамруулан чанартай зохион байгуулж, шаардагдах ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, хүн хүч, шатахуун, тээврийн хэрэгслийг сумын Засаг даргын нөөц сангаас бүрдүүлж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

б/ Лабораторийн оношилгоо, шинжилгээ, дархлаажуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтад эрсдэлтэй бүсийн мэдрэмтгий мал, амьтныг технологид хугацаанд бүрэн хамруулах

в/ Гоц халдварт өвчний голомт бүхий нутгаас мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэх, тууварлах, шаардлагагүй нөхцөлд голомт бүхий аймаг, сумдад зорчихгүй байх, хүн мал, амьтны шилжилт хөдөлгөөнд байнга хяналт тавьж ажиллах

г/ Мал амтны гоц халдварт шүлхий, цэцэг өвчний голомт бүхий сумдтай хил залгаа нутаглаж буй айл өрхийн өвөлжөө, хашаанд тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр /ДУК/ ариутгал халдваргүйжүүлэлтийг зохион байгуулах

д/ “Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аян” арга хэмжээ, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний тайланг хугацаанд нь гарган аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэх

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч дарга /М.Бямбаа/-д үүрэг болгосвгай.

ЗАСАГ ДАРГА

С. АРИУНБАТ